



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/189

Мандагновь

2020 оны Замын сангийн хөрөнгөөр  
хийгдэх ажлын жагсаалтыг батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.14, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2020 оны замын сангийн 238,162,569 төгрөгийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажилд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010541

Аймгийн Засаг даргын 2020 оны 07  
дүгээр сарын 22-ны өдрийн А/139  
захирамжийн хавсралт



**2020 ОНЫ ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР  
ХИЙГДЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ**

№	Ажлын нэр	Тайлбар	Нийт үнэ ₮
1.	Аймгийн төвийн авто замын засвар, хурд сааруулагч	1100 м2 буюу 55.4 м3 нөхөөсийн засвар, 6 ш хурд сааруулагч, 12 ширхэг замын тэмдэг	142.647.569
2.	Замын гэрэлтүүлгийн засварын материал	Замын гэрлийн толгой, цахилгааны утас солих (Айраг, Мандал, Арвижих, Нарлаг, Боржигон)	48.000.000
3.	Зам засварын материал	Хүйтэн асфальт, Давс, Мөс, цас хайлуулагч реагент бодис 37.000 м2, Зам засварын төмөр 250 м, Шохой лагшин	43.015.000
4.	Зураг төсвийн үнэ	Мандал буудал-Буянт гүүр, ТХДЖТ-УЦУОШТөв орчмын аймгийн төвийн авто замын засвар, явган хүний зам, гарц шинэчлэх 171.579.916 төсөв бүхий зураг төсөв.	4.500.000
<b>Нийт дүн</b>			<b>238.162.569</b>